

## Гадаадын иргэдийн талаарх хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн зохицуулалт: Олон улсын туршлага ба Монгол Улс

Цагаандоржийн Гэрэлтуяа \*, Энхзаяагийн Түмэнжаргал

Ахлах мэргэжилтэн, [foreignrelations@immigration.gov.mn](mailto:foreignrelations@immigration.gov.mn)  
Монгол Улс, Улаанбаатар, Гадаадын иргэн, харьяатын газар,  
Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс

### Хураангуй

Энэхүү өгүүллээр Монгол Улстай хил залгаа стратегийн хөрш Орос, Хятад болон газар нутаг, нийгэм, эдийн засгийн шилжилтийн хувьд ижил төстэй Казахстан, мөн гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг өргөн хүрээнд цахимжуулж, дасан зохицуулах бодлогыг системтэй хэрэгжүүлж буй Өмнөд Солонгосыг сонгон авч эдгээр улсын гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалт, виз болон оршин суух зөвшөөрлийн тогтолцоо, хяналт шалгалтын механизм, төрийн үйлчилгээний зохион байгуулалт, дэмжлэгийг харьцуулан шинжилсэн болно. Учир нь Нэгдүгээрт, Монголын Гадаадын иргэн, харьяатын газрын бүтэц, чиг үүрэг нь Орос, Хятад, Казахстаны холбогдох байгууллагуудтай тодорхой хэмжээнд төстэй байдаг. Хоёрдугаарт, эдгээр улс орон гадаадын иргэдийн асуудлыг төвлөрсөн удирдлагаар зохицуулж, эдийн засгийн хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад тулгуурласан бодлого хэрэгжүүлдэг нийтлэг шинжтэй. Гуравдугаарт, засаглалын загвар, төрийн үйлчилгээний цахимжилтын түвшин, ил тод байдал болон гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицуулах бодлогын хэрэгжилтэд тодорхой ялгаа ажиглагддаг нь харьцуулсан судалгаа хийх үндэслэл болсон юм.

**Түлхүүр үгс:** Визийн тогтолцоо, оршин суух зөвшөөрөл, цахимжилт, төрийн үйлчилгээ, дасан зохицуулах бодлого

### Нэг. Улс орнуудын гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг зохицуулах тогтолцоо

Дэлхийн улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч буй өнөөгийн нөхцөлд гадаадын иргэдийн эрх зүйн байдал, зорчих хөдөлгөөн, оршин суух нөхцөлийг зохицуулах тогтолцоо нь тухайн улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлэх болсон.

Гадаадын иргэдийн талаар баримтлах бодлого нь зөвхөн хилээр зорчих хөдөлгөөний хяналтаар хязгаарлагдахгүй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, өндөр ур чадвартай ажиллах хүчийг дэмжих, олон улсын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг олон талт зорилгыг хамардаг байна.

\* Холбоо барих зохиогч

Иймд гадаадын иргэдийн талаар баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь улс орон бүрийн онцлогоос шалтгаалж харилцан адилгүй.

Оросын Холбооны Улс: Гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг 2002 оны “ОХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай” Холбооны хууль (№115-ФЗ), 2006 оны “ОХУ дахь гадаадын иргэн болон харьяалалгүй хүний бүртгэлийн тухай” Холбооны хууль (№109-ФЗ), 2002 оны “Харьяатын тухай” Холбооны хууль (№62-ФЗ), “2026-2030 онд ОХУ-ын төрөөс гадаадын иргэдийн талаар баримтлах бодлогын үзэл баримтлал” зэрэг эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Эдгээр хууль тогтоомжид гадаадын иргэдийн эрх зүйн байдал, оршин суух нөхцөл, бүртгэлийн журам, харьяалал олгох үндэслэл, шалгуурыг нарийвчлан тодорхойлсон. Мөн гадаадын иргэдийн бүртгэл, оршин суух зөвшөөрөл, харьяаллын асуудлыг 2016 оноос хойш ОХУ-ын Дотоод хэргийн яамны харьяа байгууллагууд төвлөрсөн журмаар хэрэгжүүлж байна. Төв байгууллага нь бодлого боловсруулах, зохицуулалт хийх чиг үүрэгтэй бол нутаг дэвсгэрийн нэгжүүд нь иргэдэд үйлчилгээ үзүүлэх, холбогдох шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг (зарлиг, 2016).

Төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд Ерөнхийлөгчийн зарлигаар шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Иргэний харьяалал, гадаад иргэний бүртгэлийн албыг Дотоод хэргийн яамны харьяанд байгуулсан (зарлиг О.-ы. Е., 2025) нь гадаадын иргэдийн асуудлыг нэгдсэн удирдлагаар зохицуулах институцийн тогтолцоог бүрдүүлэх алхам болжээ.

**Зураг 1. Иргэний харьяалал, гадаад иргэний бүртгэлийн албаны бүтэц**



ОХУ-ын хууль тогтоомжид гадаадын иргэдийг оршин суух хугацаанаас нь хамааруулан дараах гурван үндсэн ангилалд хуваадаг. Үүнд:

*Түр ирэгч гадаадын иргэн:* Визтэй болон визгүй зорчих нөхцөлөөр ОХУ-д нэвтэрсэн, түр болон байнга оршин суух зөвшөөрөл аваагүй этгээд;

*Түр оршин суугч:* Гурван жилийн хугацаатай түр оршин суух зөвшөөрөл авсан этгээд бөгөөд уг зөвшөөрлийг жил бүр тогтоодог квотын хүрээнд олгодог;

*Байнга оршин суугч:* Таван жилийн хугацаатай байнга оршин суух зөвшөөрөл авсан этгээд бөгөөд уг зөвшөөрлийг хугацаа дууссаны дараа хязгаарлалтгүйгээр сунгах боломжтой (*“ОХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай” Холбооны хууль, 2002*).

Оршин суух зөвшөөрөл олгохдоо Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудын иргэдэд хялбаршуулсан журам хэрэглэх зохицуулалттай. Гадаадын иргэд ОХУ-ын хилээр нэвтэрснээс хойш долоо хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд бүртгэлийг ихэвчлэн уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцан хийлгэдэг.

Визгүй зорчих улсын иргэдийн хувьд “патентын тогтолцоо” нь хөдөлмөр эрхлэх үндсэн механизм болдог бөгөөд уг патент нь гадаадын иргэдийг хувь хүн болон хуулийн этгээдэд хөлсний ажилтнаар ажиллах боломжийг олгодог байна. Харин өндөр мэргэшсэн мэргэжилтэн болон тэдний гэр бүлийн гишүүдэд ажиллах зөвшөөрөл өгөх, оршин суух хугацааг сунгах зэрэгт хялбаршуулсан, хөнгөлөлттэй нөхцөлийг олгодог.

ОХУ гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах зорилгоор Ерөнхийлөгчийн зарлигаар “Гадаадын иргэний дижитал профайл” системийг бий болгож, гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, ажил эрхлэлт, нийгмийн даатгалын мэдээллийг нэгтгэн “Gosuslugi” портал болон “ruID аппликейшн”-аар дамжуулан үйлчилгээ үзүүлэх болжээ (*зарлиг О.-ы. Е., 2025*).

Гадаадын иргэдэд чиглэсэн дэмжлэгийн хүрээнд орос хэл, түүх, хууль тогтоомжийн талаарх суурь мэдлэг эзэмшсэн гадаадын иргэдийн харьяат болох хүсэлтийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зохицуулалт бий. Үүнээс гадна гадаад улсад оршин суугаа орос угсаатнуудыг сайн дурын үндсэн дээр шилжин суурьшихад дэмжлэг үзүүлэх төрийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөр нь оршин суух зөвшөөрөл, иргэншлийг хялбаршуулсан журмаар олгох, шилжин суурьшихтай холбоотой санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн нийгмийн баталгааны тодорхой хөнгөлөлтийг эдлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь нэг талаас хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангах, нөгөө талаас түүхэн, соёлын холбоо бүхий иргэдийг татах замаар улсын хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой хэрэгжиж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Гадаадын иргэдийн хилээр орох, гарах болон оршин суухтай холбоотой харилцааг “БНХАУ-ын хилээр орох-гарах хяналтын тухай хууль”-иар зохицуулдаг. Түүнчлэн уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “БНХАУ-ын хилээр орох-гарах хөдөлгөөний хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”,

“Гадаадын иргэний орох-гарах, зорчих, оршин суух тухай журам” зэрэг холбогдох эрх зүйн акт батлан хэрэгжүүлж байна. Гадаадын иргэдэд олгох визийг зорчих зорилгоос нь хамааран 13 үндсэн ангилалд хуваадаг. “К” ангиллын визийг 2025 оны 10 дугаар сарын 01-нээс шинээр нэвтрүүлж, гадаадын залуу судлаач, технологийн салбарын авьяастнуудад чиглэсэн тусгай нөхцөл бүхий зөвшөөрөл олгож эхэлсэн ((SAFEA), 2018). Энэхүү виз нь тодорхой нас, боловсролын шалгууртай бөгөөд дотоодын компаниас заавал урилга шаардахгүйгээр шинжлэх ухаан, соёл, бизнес, инновацын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх боломж олгодог ороо онцлог юм.

Гадаадын иргэдийн түр болон байнгын оршин суух зөвшөөрлийн хувьд “найдвартай гадаадын иргэн”-д таван жилийн хугацаатай олон удаагийн виз олгох, мөн “БНХАУ-д байнгын оршин суух үнэмлэх” (外国人永久居留身份证) олгох зохицуулалт хэрэгждэг байна. Байнгын оршин суух зөвшөөрлийг эдийн засагт оруулсан хувь нэмэр, хөрөнгө оруулалтын хэмжээ, мэргэжлийн ур чадвар, тухайн улсад ажилласан хугацаа зэрэг шалгуурт үндэслэн хязгаарлагдмал тооны гадаадын иргэдэд олгодог.

Гадаадын иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор өмнө мөрдөж байсан 72 болон 144 цагийн визгүй зорчих зохицуулалтыг нэгтгэн шинэчилж, 240 цагийн визгүй дамжин өнгөрөх бодлогыг 2024 оны сүүлчээс хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү бодлогын хүрээнд 55 улсын иргэд 24 мужийн 65 боомтоор дамжин **10 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчих** боломжтой болсон ((SCIO), 2025, November 4 ). Албан ёсны статистик мэдээллээр 2025 оны байдлаар хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн тоо 40.6 саяд хүрч, өмнөх оноос 27.2 хувиар өсчээ. Үүнээс визгүй дамжин өнгөрөх зохицуулалтыг ашигласан гадаадын иргэдийн тоо 60.8 хувиар нэмэгдсэн нь зорчих нөхцөлийг хөнгөвчилсөн бодлогын үр нөлөөг илэрхийлж байгаа юм (China, 2026 ). Мөн гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийж, 2026 оноос 11 яам, байгууллага хамтран “Гадаадын иргэдэд үзүүлэх цахим үйлчилгээг сайжруулах тухай удирдамж”-ийг баталж, 14 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан (Administration), 2026, February 12 ). Үүнд: харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, гадаад цахим төлбөрийн хэрэгслийг дэмжих, олон хэлний цахим үйлчилгээ нэвтрүүлэх, аялал жуулчлал, худалдаа, эрүүл мэнд, боловсрол, бизнес болон төрийн үйлчилгээний салбарт цахим шийдлийг өргөжүүлэх зэрэг багтжээ. Түүнчлэн томоохон олон улсын нисэх буудлуудад нэг цэгийн үйлчилгээ болон цахим урьдчилсан бүртгэлийн систем нэвтрүүлснээр хил нэвтрэх үйл явцын хугацаа дунджаар 15 минутаар буурсан байна.

БНХАУ өндөр ур чадвартай мэргэжилтэн, хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор “R” ангиллын визийг нэвтрүүлж, стратегийн ач холбогдолтой салбаруудад шаардлагатай гадаадын мэргэжилтнүүдийг татах бодлогыг хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ Бээжин, Шанхай, Гуанжоу зэрэг томоохон хотод гадаадын иргэдэд зориулсан тусгай үйлчилгээний төвүүд ажиллаж, виз сунгах, оршин суух

зөвшөөрөл авах, татварын бүртгэл хийх зэрэг төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлжээ.

Статистик мэдээллээс үзвэл **2025 оны байдлаар Шанхайд 5.35 сая, Гуанжоуд 3.2 сая гадаадын иргэн зорчсон** бөгөөд тэдгээрийн талаас илүү хувь нь визгүй зорчих нөхцөлөөр хилээр нэвтэрсэн байна. Энэ нь БНХАУ-ын гадаадын иргэдийн зорчих хөдөлгөөнийг хөнгөвчлөх, эдийн засгийн хамтын ажиллагаа, аялал жуулчлалыг дэмжих бодлого амжилттай хэрэгжиж байгааг харуулж байна.


Гадаадын иргэдийн хил нэвтрэлт, оршин суух асуудлыг улсын хэмжээнд зохион байгуулах эрх бүхий төв байгууллага нь БНХАУ-ын Улсын цагаачлалын удирдах газар (National Immigration Administration) юм. Харин орон нутгийн түвшинд Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын харьяа Цагаачлалын хяналтын цэгүүд (出入境边防检查站) ажиллаж, хилийн хяналт шалгалт, гадаадын иргэдийн бүртгэл, зорчих хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлдэг (*БНХАУ-ын Хилээр орох-гарах хяналтын тухай хууль*, 2012).

### Зураг 2. Улсын цагаачлалын удирдах газрын бүтэц



Бүгд Найрамдах Солонгос Улс: Гадаадын иргэдийн хил нэвтрэх, оршин суухтай холбоотой харилцааг “Цагаачлалын тухай хууль” (출입국관리법)-иар зохицуулна. Гадаадын иргэдийн асуудлыг эрхлэн хариуцах байгууллага нь Хууль зүйн яамны харьяа Цагаачлалын алба (Korea Immigration Service) бөгөөд бодлого боловсруулах, оршин суух зөвшөөрөл, хяналт, харьяалал зэрэг чиг үүргийг төвлөрсөн байдлаар хэрэгжүүлдэг.

**Зураг 3. Цагаачлалын албаны бүтэц**



Гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх бодлогын хүрээнд HiKorea ([www.hikorea.go.kr](http://www.hikorea.go.kr)) нэгдсэн портал системийг нэвтрүүлж, визийн мэдүүлэг гаргах, оршин суух хугацаа сунгах, визийн ангилал өөрчлөх, хаягийн өөрчлөлт бүртгүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл шинэчлэх зэрэг олон төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлжээ. 2026 оноос эхлэн “Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн дэвшилтэт систем” (HiKorea Employment Reporting)-ийг ашиглалтад оруулснаар гадаадын иргэд ажлын байрны мэдээллээ цахимаар бүртгүүлэх, шинэчлэх боломжтой болсноор биечлэн бүртгүүлэх шаардлага эрс буурсан байна.

Тус улсын визийн тогтолцоо нь зорчих зорилгоос хамааран хөдөлмөр эрхлэлт, суралцах, хөрөнгө оруулалт, гэр бүл нэгтгэх зэрэг олон төрлийн ангилалтай. Тухайлбал: “E-7” ангиллын визийг судлаач, профессор, технологийн мэргэжилтэн зэрэг өндөр ур чадвар, мэргэшил бүхий гадаадын ажилтнуудад олгодог бол “F-4” ангиллын визийг гадаадад оршин суугаа солонгос угсаатанд олгодог. Энэ оны хоёрдугаар сараас эхлэн “F-4” визийн хамрах хүрээг өргөжүүлж, харьяалал харгалзахгүйгээр гадаадад амьдарч буй солонгос угсаатнууд мэдүүлэх боломжтой болсон (Ministry of Justice, 2025).

Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, хүн амын бууралтыг харгалзан гадаад ажиллах хүчний бодлогод сүүлийн жилүүдэд тодорхой өөрчлөлтүүдийг хийж байна. Тухайлбал: “E-9” ангиллын визийн квотыг 80 мянга орчимд хүргэж, “E-8” ангиллын визийг 109 мянга хүртэл нэмэгдүүлсэн бол “E-10” ангиллын визийн

хэмжээг өмнөх оны түвшинд хэвээр хадгалжээ. Ингэснээр хувийн хэвшлийн салбарт авах гадаадын ажиллах хүчний тоог нийт 190 мянга гаруй хүнээр нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа нь хөдөлмөрийн хүчний хомсдолыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ юм (Ministry of Employment and Labor, 2024).

Мөн бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зорилгоор нийслэлээс бусад бүсэд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн компаниудын гадаадаас ажилтан авах дээд хязгаарыг 20 - 30 хувь болгон нэмэгдүүлсэн (Ministry of Employment and Labor, Implementation Guidelines for Foreign Worker Quota Expansion in Non-metropolitan Manufacturing Companies. Seoul: Korea Employment Information Service, 2024). Түүнчлэн гадаадаас үйл ажиллагаагаа шилжүүлэн ирж, нийслэлээс бусад бүс нутагт суурьшсан компаниудад гадаад ажилтан авах боломжийг өргөжүүлж, өмнө мөрдөж байсан **50 хүртэлх хүний дээд хязгаарыг цуцалсан** байна.

Хөдөлмөрийн хөлсний бодлогын хувьд 2026 онд нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **10030 воноос 10320 вон** болгон 2.9 хувиар нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд долоо хоногт 40 цаг (сард 209 цаг) ажиллах тохиолдолд сарын доод цалин **2096270 воноос 2156880 вон** болж өссөн бөгөөд ажил хайх хугацааны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж зэрэг хөдөлмөр эрхлэлтийн даатгалын сангаас олгодог зарим тэтгэмжийн хэмжээ даган нэмэгдсэн байна (Ministry of Employment and Labor, Official Announcement on the Minimum Wage for the Year 2026. Seoul: Government Press, 2025).

БНСУ нь гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицуулах бодлогыг идэвхтэй хэрэгжүүлдгээрээ онцлогтой. “КИП (Korea Immigration and Integration Program)” буюу гадаадын иргэдийг дасан зохицуулах цогц хөтөлбөрийг 2009 оноос хэрэгжүүлж солонгос хэл, соёл, нийгмийн тогтолцооны талаарх мэдлэг олгож, гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлж байна. “КИП” хөтөлбөрийг Хууль зүйн яамнаас зөвшөөрөл авсан байгууллагууд хэрэгжүүлж, уг сургалтыг амжилттай төгссөн тохиолдолд оршин суух зөвшөөрөл сунгах, байнгын оршин суух эрх авах, харьяат болох хүсэлт гаргахад тодорхой давуу тал олгоно. Тухайлбал: “КИП”-ийн эцсийн үнэлгээг амжилттай давсан гадаадын иргэд харьяат болох хүсэлт гаргах үед ярилцлага болон бичгийн шалгалтаас чөлөөлөгдөх боломжтой. Мөн “F-2-7” виз мэдүүлэхэд “КИП”-ийн түвшнээс хамааран 10-28 хүртэлх онооны нэмэгдэл авах, зарим визийн ангилалд солонгос хэлний мэдлэгийг нотлох шаардлагаас чөлөөлөгдөх зэрэг давуу талтай байна.

БНСУ-д 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэд анхны оршин суух хаягаа бүртгүүлэх, мөн хаяг өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор шинэ хаягаа бүртгүүлэх үүрэгтэй. Бүртгэлийг тухайн орон нутгийн гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, дүүргийн (gu) захиргаа, эсвэл хорооны (dong) үйлчилгээний төвөөр дамжуулан хийхээс гадна HiKorea ([www.hikorea.go.kr](http://www.hikorea.go.kr)) системээр цахимаар бүртгүүлэх боломжтой бөгөөд ихэвчлэн ажлын гурван хоногийн дотор шийдвэрлэгддэг.

Гадаадын иргэдэд чиглэсэн дэмжлэгийн бодлогын хүрээнд дараах үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- “КПР” хөтөлбөр: Солонгос хэл, соёлын үнэ төлбөргүй сургалт;
- *Нэг цэгийн үйлчилгээний төвүүд*: Томоохон хотуудад гадаадын иргэдэд зөвлөгөө, мэдээлэл, захиргааны үйлчилгээ үзүүлэх төвүүд;
- *Гадаадын иргэдийн мэдээллийн төв (1345)*: Олон хэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх улсын нэгдсэн дугаар зэрэг гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн гадаад ажиллах хүчний бодлогыг уян хатан болгох, мөн “КПР” зэрэг нийгэмд дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар цагаачлалын удирдлагын тогтолцоог илүү хүртээмжтэй, үр ашигтай, нэгдмэл болгоход чиглэсэн бодлого баримталж байна.

**Бүгд Найрамдах Казахстан Улс:** Гадаадын иргэдийн хилээр орох, гарах, оршин суухтай холбоотой харилцааг 2011 онд баталсан “Хүн амын шилжилт хөдөлгөөний тухай” хуулиар зохицуулдаг. “Казахстан дахь гадаадын иргэнийг бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, 2026 оны зунаас хэрэгжүүлэхээр болсон. Уг журамд цагаач (иммигрант) гэсэн ойлголтыг Казахстанд түр болон байнга оршин суухаар ирсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэж тодорхойлсон байна. Гадаадын иргэдийн бүртгэлийг “Цагаачлалын мэдээллийн систем”-ээр дамжуулан цахимаар хийхээр зохицуулсан нь төрийн үйлчилгээний цахимжилтыг ахиулсан чухал алхам болсон гэж үзэж байна (хороо, 2025, November 17).

Журамд зааснаар 90 хүртэлх хоногийн хугацаанд оршин суух гадаадын иргэн хилээр нэвтэрснээс хойш 30 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй. Бүртгэл хийлгэхдээ гадаадын иргэн өөрийн овог, нэр, төрсөн огноо, паспортын мэдээлэл, уригч этгээдийн мэдээлэл болон оршин суух хаяг зэрэг шаардлагатай мэдээллийг системд оруулна. Харин уригч тал гар утасны аппликейшнээр дамжуулан уг бүртгэлийг баталгаажуулснаар цахим бүртгэлийн гэрчилгээ автоматаар үүсэх зохицуулалттай байна.

Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгохын тулд гадаадын иргэдийн бүртгэлийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх, хилээр нэвтрэх үед олгодог “гадаадын иргэний бүртгэлийн карт” (мигрант ID картасы)-ыг ашиглалтад оруулах, 30 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэдийг цахимаар хянах, мөн хиймэл оюунд суурилсан дүн шинжилгээ ашиглан оршин суух зорилго, хугацаанд хяналт тавих зэрэг арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эдгээр шинэчлэлийн зорилго нь зохиомол бүртгэл, хууль бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, гадаадын иргэдийн хөдөлгөөний талаарх мэдээллийг илүү нарийвчлалтай боловсруулах явдал юм. Казахстанд байнга оршин суух гадаадын иргэдийн тоо өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 1.5 дахин өссөн бөгөөд зөвхөн 2025 оны тавдугаар сард л гэхэд 7 мянга гаруй зөрчил илэрсэн нь гадаадын иргэний хяналт, зохицуулалтыг чангатгах шаардлагатай гэж үзэхэд хүргэжээ (Kazakhstan,

2025). Мөн жилд дунджаар 724 мянган орчим гадаадын ажиллах хүч хүлээн авдаг бөгөөд 2023 онд гадаадын иргэдийн урсгал өмнөх онтой харьцуулахад 47 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тус улсын Хөдөлмөрийн тухай хуульд харьяалал, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхахыг хориглож, гадаадын иргэд хөдөлмөрийн нөхцөл, ажлын хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын цагийн зохицуулалтын хувьд Казахстаны иргэдтэй **адил тэгш эрх эдлэх** эрх зүйн баталгааг тогтоосон. Мөн ажил олгогч хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, баталгааг тодорхой тусгах үүрэгтэй. Үүнээс гадна гадаадад оршин суугаа казах угсаатнуудыг эх оронд нь буцаан суурьшуулах бодлогын хүрээнд “Оралман” хөтөлбөрийг хэрэгжүүлж, улмаар “Кандас” нэртэй цахим платформыг ашиглан бүртгэл, үйлчилгээ үзүүлж байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн гадаадын мэргэжилтэн сонгон шалгаруулах, цахим бүртгэлийн тогтолцоог улам боловсронгуй болгох, хууль бус хөдөлмөр эрхлэлт болон сүүдрийн эдийн засагтай тэмцэх, хөдөлмөрийн квотын тогтолцоог шинэчлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Цахим засаглалын хүрээнд eGov.kz нэгдсэн портал ашиглан гадаадын иргэдэд чиглэсэн олон төрлийн төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Гэвч бүртгэлийн зарим хатуу журам, орон нутгийн байгууллагуудын шийдвэр гаргах өргөн эрх мэдэл, түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилт бүс нутгаас хамаарч ялгаатай байх зэрэг хүндрэл ажиглагдах болжээ. Иймээс Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шинэчлэл, мэдээллийн нэгдсэн платформ бий болгох, гадаадын иргэний бүртгэлийн карт нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ нь гадаадын иргэдийн талаарх удирдлагын тогтолцоог илүү ил тод, үр ашигтай, нэгдмэл болгоход чиглэж байна.

Гадаадын иргэдийн бүртгэл, оршин суухтай холбогдсон асуудлыг Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын албаны хороо (Комитет миграционной службы) эрхлэн хэрэгжүүлдэг бол хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран хариуцдаг тогтолцоотой байна.


**Зураг 4. Цагаачлалын албаны хорооны бүтэц**



### Хоёр. Монгол Улсын гадаадын иргэний асуудал, оршин суух зохицуулалтын тогтолцоо

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Гадаадын иргэн, харьяатын газар (ГИХГ) бөгөөд тус байгууллага нь төрийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ үндэсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллага гэдгээрээ онцлогтой. Мөн Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн чиг үүрэгт гадаадын иргэнд виз, оршин суух зөвшөөрөл олгох, иргэний харьяалалтай холбоотой процессын үйл ажиллагаа хийх, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, гадаадын иргэн, гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс эхлэн буцаж гарах хүртэлх хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг багтана. Тус байгууллага нь орон нутгийн түвшинд салбар нэгжүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Зураг 5. Гадаадын иргэн, харьяатын газрын бүтэц



Монгол Улсад гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөл, бүртгэл, хяналттай холбоотой харилцааг үндсэндээ “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-иар зохицуулдаг. Харин уг хуулийн хэрэгжилтийг нарийвчлан зохицуулах зорилгоор “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух, түүнийг бүртгэх журам” зэрэг Засгийн газрын тогтоолоор баталсан эрх зүйн актуудыг мөрдүүлж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын визийн тогтолцоо нь зорчих зорилгоос хамааран дипломат, албан, түр ирэгч, гэр бүл, хөдөлмөр эрхлэх, суралцах, хөрөнгө оруулагч зэрэг 64 төрлийн ангилалд хуваадаг (тогтоол, 2021). Засгийн газраас **2023-**

2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбоотойгоор гадаадын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах зорилгоор цахим виз олгох улс орнуудын жагсаалтыг өргөтгөж, виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой олон төрлийн үйлчилгээг цахимаар мэдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Хууль тогтоомжийн дагуу гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш 48 цагийн дотор бүртгэл хийлгэх үүрэгтэй бөгөөд виз, визийн зөвшөөрөл мэдүүлэх үед оршин суух хаягийн баталгаажуулалт заавал ирүүлэх шаардлагатай байдаг. Хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ГИХГ нь Хууль сахиулах байгууллагууд болон төрийн бусад байгууллагатай хамтран ажилладаг.

Монгол Улс гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлж 2025 оны эхний улирлын байдлаар виз болон оршин суух зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг бүрэн цахимжуулсан нь дараах зэрэг өөрчлөлтийг дагуулсан. Тухайлбал:

- 2021 оноос хойш 200 мянга гаруй гадаадын иргэнд цахимаар үйлчилгээ үзүүлсэн;
- Өдөрт биечлэн үйлчлүүлэгчдийн тоо 240-520 байснаас 5-8 болж буурсан;
- Өмнө нь өдөрт 100-150 хүсэлтийг цаасаар хүлээн авч шийдвэрлэдэг байсан бол 700-1100 хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх боломж бүрджээ (Гадаадын иргэн, 2025).

Цахимжуулалтын үр дүнд гадаадын иргэд, тэдгээрийн уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал мэдэгдэхүйц сайжирсан. Өөрөөр хэлбэл: Монгол Улсын гадаадын иргэний бүртгэл, оршин суух зохицуулалтын тогтолцоонд сүүлийн жилүүдэд тодорхой ахиц гарсан байна. Гэсэн хэдий ч мэдээллийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, хиймэл оюунд суурилсан шийдлийг хөгжүүлэх, кибер аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг асуудал нь цаашид анхаарах шаардлагатай хүндрэл, сорилтуудын нэг хэвээр байна. Тухайлбал:

- Нэгдүгээрт, цахим системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн хамгаалалтыг сайжруулах шаардлага;
- Хоёрдугаарт, гадаадын иргэдийн тоо нэмэгдэж буйтай холбоотойгоор хууль бусаар оршин суух, баримт бичгийн хуурмаглал зэрэг зөрчил буурахгүй байгаатай тэмцэх хяналтын механизмыг боловсронгуй болгох;
- Гуравдугаарт, визгүй зорчих нөхцөлөөр Монгол Улсад түр ирж буй гадаадын иргэдийн хөдөлгөөнд тавих хяналтын тогтолцоог сайжруулах шаардлага зэрэг болно.

### Гурав. Монгол Улсын тогтолцоог гадаад улстай харьцуулах нь

Гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэгч салбар нь тухайн улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, олон улсын хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг болно. Монгол Улсын гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоог дээр дурдсан Орос, Хятад, Казахстан, Өмнөд Солонгос зэрэг улсын тогтолцоотой харьцуулан авч үзье.

Харьцуулалтыг хууль эрх зүйн үндэс ба институцийн бүтэц, визийн тогтолцоо, оршин суух зөвшөөрлийн механизм, гадаадын иргэдийг дасан зохицуулах бодлого болон цахим үйлчилгээ ба дижитал хөгжлийн түвшин гэсэн үндсэн таван чиглэлээр хийсэн болно.

#### Хүснэгт 1. Хууль эрх зүйн үндэс ба институцийн тогтолцооны харьцуулалт

Улс	Үндсэн хууль, эрх зүйн акт	Хариуцсан байгууллага	Тогтолцооны онцлог
Монгол	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль	Гадаадын иргэн, харьяатын газар (ГИХГ)	Хууль нь ерөнхий зохицуулалттай, олон асуудлыг дагалдах журмаар зохицуулдаг
Орос	ОХУ-д гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай холбооны хууль (№115-ФЗ)	Дотоод хэргийн яамны Цагаачлалын нэгж	Түр ирэгч, түр оршин суух, байнга оршин суух гэсэн шатлалтай систем
Хятад	Хилээр орох-гарах хөдөлгөөний хяналтын тухай хууль	Улсын цагаачлалын удирдах газар	Төвлөрсөн удирдлагатай, хил болон оршин суух хяналт нягт
Өмнөд Солонгос	Цагаачлалын тухай хууль	Хууль зүйн яамны Цагаачлалын алба	Виз, оршин суух, дасан зохицох бодлогыг нэгдсэн системээр хэрэгжүүлдэг
Казахстан	Хүн амын шилжилт хөдөлгөөний тухай хууль	Дотоод хэргийн яамны Цагаачлалын албаны хороо	Бүртгэл, хөдөлгөөний хяналтад онцгой анхаарал хандуулдаг

*Тайлбар: Монгол Улсын хууль эрх зүйн үндэс нь эдгээр улсын ерөнхий загвартай төстэй боловч институцийн бүтэц, хүний нөөц, чиг үүргийн цар хүрээний хувьд харьцангуй хязгаарлагдмал байна. Харин БНХАУ болон БНСУ зэрэг орны хувьд цагаачлалын удирдлагын байгууллагын бүтэц илүү өргөн хүрээтэй, олон чиг үүргийг хамарсан тогтолцоотой байна.*

### Хүснэгт 2. Визийн тогтолцооны харьцуулалт

Улс	Визийн ангилал	Цахим виз	Онцлог
Монгол	64 ангилал	197 улсын иргэдэд	2024 оноос бүх ангиллын уригчтай визийг цахимаар олгож эхэлсэн
Орос	Олон төрлийн зорилгот виз	Хязгаарлагдмал	Виз нь оршин суух статусын шатлалтай уялдаг
Хятад	13 үндсэн ангилал	Зарим хэлбэрээр	Шинжлэх ухаан, технологийн чиглэлд тусгай виз (K, R)
Өмнөд Солонгос	40+ ангилал	Хязгаарлагдмал	Виз, хөдөлмөр, оршин суух зөвшөөрөл нэг системд
Казахстан	Хөдөлмөр, бизнес, хөрөнгө оруулалт гэх мэт	Хязгаарлагдмал	Бүртгэлд илүү төвлөрсөн бодлого

*Тайлбар:* Визийн ангилал, зохицуулалтын нарийвчлалын хувьд БНХАУ болон БНСУ нь гадаадын иргэдийн зорчих зорилго, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй уялдсан илүү нарийн ангиллын тогтолцоог хэрэгжүүлж байгаа бол Монгол Улсын хувьд визийн ангиллын бүтэц тодорхой, цахим визийн системийг өргөжүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодит ахиц гарсан байна.

### Хүснэгт 3. Оршин суух зөвшөөрлийн тогтолцооны харьцуулалт

Улс	Оршин суух ангилал	Шатлал	Онцлог
Монгол	Гэр бүл, хөдөлмөр, суралцах, хөрөнгө оруулалт г.м зорилгоор	Хязгаарлагдмал	Зорилго, зориулалтаар ангилсан
Орос	Түр ирэгч-Түр оршин суух-Байнгын оршин суух	Тодорхой шатлалтай	РВП→ВНЖ шилжилтийн систем
Хятад	Түр болон байнгын оршин суух	Хязгаарлагдмал	Байнгын оршин суух эрхийг хязгаарлагдмал олгодог
Өмнөд Солонгос	Визтэй уялдсан оршин суух	Шатлалтай	E→F→байнгын оршин суух систем
Казахстан	Түр болон байнгын	Бүртгэлд суурилсан	Цагаачлалын мэдээллийн системээр хяналт

*Тайлбар:* Оршин суух зөвшөөрлийн тогтолцооны хувьд ОХУ болон БНСУ нь тодорхой шатлал бүхий системийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь гадаадын иргэдийн эрх зүйн статусыг үе шаттайгаар тодорхойлох давуу талтай байна. Монгол Улс оршин суух зөвшөөрлийг зорилго, зориулалтаар нь ангилан олгодог.

**Хүснэгт 4. Гадаадын иргэдийг дасан зохицуулах бодлогын харьцуулалт**

Улс	Дасан зохицох хөтөлбөр	Онцлог
Монгол	Системтэй хөтөлбөр байхгүй	Хэл, соёлын сургалтын тогтолцоо сул
Орос	Орос хэл эзэмшсэн төрөлх хэлтэн хөтөлбөр	Иргэншил авахад хөнгөлөлт
Хятад	Хязгаарлагдмал	Эдийн засгийн хувь нэмрийг илүү харгалздаг
Өмнөд Солонгос	КИП (Integration Program)	Хэл, соёл, нийгмийн сургалт+иргэншилд давуу тал
Казахстан	Оралман хөтөлбөр	Казах угсаатныг эх оронд нь буцаан суурьшуулах

*Тайлбар: Гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицуулах бодлогын хувьд ОХУ, БНСУ, БНКаЗУ хэл, соёл, хууль эрх зүйн мэдлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Эдгээр хөтөлбөр нь гадаадын иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхээс гадна оршин суух болон иргэншил авах үйл явцад тодорхой давуу тал олгодог байна. Харин Монгол Улсад гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицуулах чиглэлээр системтэй, институцилсэн хөтөлбөр хангалттай хөгжөөгүй байна.*

**Хүснэгт 5. Цахим үйлчилгээ, дижитал шилжилтийн харьцуулалт**

Улс	Цахим систем	Үйлчилгээний хамрах хүрээ	Онцлог
Монгол	ГИХГ-ын виз, зөвшөөрлийн цахим систем	Виз, оршин суух зөвшөөрөл	2020-2024 онд эрчимтэй цахимжсан
Орос	Бүс нутгийн системүүд	Хязгаарлагдмал	Цахимжилт бүс нутгаас хамаарч харилцан адилгүй
Хятад	Хотуудад төвлөрсөн систем	Хил, виз	Том хотуудад илүү хөгжсөн
Өмнөд Солонгос	HiKorea	Виз, ажил, хаяг, оршин суух	Цагаачлалын бүрэн цахим систем
Казахстан	eGov.kz	Төрийн бүх үйлчилгээ	Нэгдсэн цахим засаглал

*Тайлбар: Цахим үйлчилгээний хөгжлийн түвшиний хувьд БНСУ болон БНКаЗУ нь төрийн үйлчилгээний нэгдсэн платформуор дамжуулан цагаачлалын үйлчилгээний ихэнхийг цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Монгол Улс виз болон оршин суух зөвшөөрлийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр тодорхой ахиц гаргасан хэдий ч уг систем нь төрийн бусад цахим үйлчилгээтэй бүрэн уялдаагүй, салангид байдлаар хэрэгжиж байна.*

Харьцуулсан шинжилгээнээс харахад гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь улс орнуудын аюулгүй байдал, нийгэм, соёлын онцлог, эдийн засгийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй уялдан өөр өөрийн онцлогтойгоор хөгжсөн байна.

### Дөрөв. Дүгнэлт, санал

Монгол Улсын цагаачлалын тогтолцоог хөрш болон Монгол Улстай шилжилт хөдөлгөөн идэвхтэй явагддаг бүс нутгийн хоёр улсын тогтолцоотой харьцуулан судлахад дараах байдлууд ажиглагдаж байна. Иймд дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Институцийн зохион байгуулалтын хувьд Орос цагаачлалын асуудлыг Дотоод хэргийн яамны бүтцэд харьяалагдах нэгжээр дамжуулан хэрэгжүүлдэг бол Монгол, Хятад, Казахстан, Өмнөд Солонгост цагаачлалын асуудлыг холбогдох яамны харьяанд ажиллах төвлөрсөн чиг үүрэг бүхий байгууллага хэрэгжүүлдэг байна.
2. Байгууллагуудын чиг үүргийн хүрээнд тодорхой ялгаа ажиглагдсан нь Казахстанд цагаачлалын байгууллага нь гадаадын иргэдийн бүртгэл, хяналтаас гадна иргэдийн паспорт, иргэний бүртгэлийн зарим чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг бол Өмнөд Солонгос болон Хятадад цагаачлалын байгууллага нь улсын хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд шууд оролцож, хилийн хяналтын чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг онцлогтой байна.
3. Засаглалын загварын хувьд Өмнөд Солонгос гадаадын иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг цахим шийдэлд тулгуурласан, үйлчилгээ төвтэй хэлбэрээр хөгжүүлсэн бол Орос, Хятад, Казахстаны тогтолцоо нь иргэдэд чиглэхээс илүүтэй аюулгүй байдлаа хангах хяналтын чиг баримжаа илт давамгайлсан шинжтэй байна.
4. Гадаадын иргэдийг нийгэмд дасан зохицуулах чиглэлээр Өмнөд Солонгосын хэрэгжүүлж буй КИР хөтөлбөртэй харьцуулахад Монгол Улсад энэ төрлийн төрийн бодлого, дэмжлэгийн тогтолцоо харьцангуй сул байна.

Монгол Улс гадаадын иргэдэд зориулсан монгол хэл, түүх, соёл, хууль тогтоомжийн суурь мэдлэг олгох цогц сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, тус хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн гадаадын иргэдэд оршин суух зөвшөөрөл сунгах, байнгын оршин суух эрх авах, улмаар харьяат болох үйл явцад тодорхой хөнгөлөлт үзүүлэх чиг бодлогыг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлж болох юм. Казахстаны цагаачлалын цагдаагийн (ИС МП) нэгдсэн мэдээллийн сан, бодит цагийн хяналтын систем нь гадаадын иргэдийн хөдөлгөөнийг илүү үр дүнтэй бүртгэх, мэдээллийг нэгдсэн байдлаар боловсруулах, хууль бусаар оршин суухаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой болох нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан дөрвөн улсын туршлага, ялангуяа Өмнөд Солонгосын интеграцийн хөтөлбөр, Казахстаны нэгдсэн цахим портал, Оросын шаталсан оршин суух тогтолцоо зэрэг нь цагаачлалын бодлогыг боловсронгуй болгоход дөхөм үзүүлсэн байна. Цагаачлалын бодлогыг шинэчлэхдээ аюулгүй байдал, эдийн засгийн ашиг сонирхол, хүний эрхийг хангах зарчмуудыг тэнцвэртэй хослуулсан байх нь зүйтэй гэж үзэж байна.

### Эх сурвалжийн жагсаалт

- “ОХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай” Холбооны хууль. (2002).
- (SAFEA), Б.-ы. Г. (2018). *Гадаадын авьяастны визний тогтолцоог хэрэгжүүлэх удирдамж (外国人才签证制度实施办法)*.
- (SCIO), Б.-ы. Т. (2025, November 4 ). *240 цагийн визгүй дамжин өнгөрөх хөтөлбөрийг өргөжүүлж, боомтын тоог 65-д хүргэх тухай*.
- Administration), Б.-ы. У. (2026, February 12 ). *Гадаадын иргэдэд үзүүлэх дижитал үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, орчныг оновчтой болгох тухай удирдамж*.
- China, S. C. (2026 ). *Report on the Growth of Inbound Foreign Visitors in 2025. Beijing*.
- Kazakhstan, G. o. (2025). *Report on Combating Illegal Labor Migration and Fraudulent Registrations using AI*.
- Ministry of Employment and Labor, R. o. (2024). *Announcement on the Quota for Foreign Workers (E-9, E-8, E-10) for 2025. Seoul: Korea Employment Information Service*.
- Ministry of Employment and Labor, R. o. (2024). *Implementation Guidelines for Foreign Worker Quota Expansion in Non-metropolitan Manufacturing Companies. Seoul: Korea Employment Information Service*.
- Ministry of Employment and Labor, R. o. (2025). *Official Announcement on the Minimum Wage for the Year 2026. Seoul: Government Press*.
- Ministry of Justice, R. o. (2025). *Specific Activities (E-7) Visa: Employment of Foreign Skilled Workers. Seoul: MOJ*.
- БНХАУ-ын Хилээр орох-гарах хяналтын тухай хууль . (2012).
- Гадаадын иргэн, х. г. (2025). *Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны тайлан*.
- зарлиг, О.-ы. Е. (2016). *Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудлын тухай*.
- зарлиг, О.-ы. Е. (2025 ). *Гадаадын иргэний дижитал профайл системийн тухай*.
- зарлиг, О.-ы. Е. (2025). *Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудлын тухай*.
- тогтоол, М. У. (2021). *Монгол Улсын виз олгох журам* .
- хороо, Б.-ы. Д. (2025, November 17 ). *Казахстан Улсад иммигрант бүртгэх дүрэм (№923 тушаал)*.

## Governing foreign nationals through policy and legal frameworks: Comparative international practices and the Mongolia

Gereltuya Tsagaandorj\* & Tumenjargal Enkhzaya

Senior Specialist, [foreignrelations@immigration.gov.mn](mailto:foreignrelations@immigration.gov.mn)

Department of Foreign Relations,

Research and Cooperation Immigration Agency of Mongolia,  
Ulaanbaatar, Mongolia

### **Abstract**

*This article presents a comparative analysis of legal frameworks governing foreign nationals, including visa and residency systems, monitoring mechanisms, and the structure of government services across selected countries. The study focuses on Mongolia's strategic neighbors Russia and China as well as Kazakhstan, which shares geographic and socio-economic transition characteristics, and South Korea, a country actively advancing digital transformation and integration policies for foreign residents. The selection of these countries is based on the following rationale.*

*First, the organizational structure and core functions of the Immigration Agency of Mongolia demonstrate significant similarities with the corresponding authorities in Russia, China, and Kazakhstan. Second, these countries generally administer foreign national affairs through centralized governance systems, implementing policies aligned with their economic priorities and labor market demands. Third, variations in governance models, levels of public service digitalization, degrees of transparency, and the effectiveness of social integration policies provide a robust basis for meaningful comparative analysis.*

**Keywords:** *Legal status of foreign nationals, comparative study, digital service, integration policy*

---

\* Corresponding author